



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 40,405,454.18 (дөчин сая дөрвөн зуун таван мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 32,988,784.64 (гучин хоёр сая есөн зуун наян найман мянга долоон зуун наян дөрвөн төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Өвөрхангай-А33А” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Хархорин-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрах, “Өвөрхангай-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлэн бүртгүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001491

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 158...
дугаар тогтоолын хавсралт

**"Хархорин-АЗЗА" ТӨХК-ийн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг "Өвөрхангай-АЗЗА"
ТӨХК-д балансаас балансад шилжүүлэх эргэлтийн хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон он	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Самсунг маркийн 95- 77 УБ улсын дугаартай, экскаватор, арлын дугаар MX132WECY12BO	2008	1	40,405,454.18	32,988,784.64	7,416,669.54
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН			40,405,454.18 (дөчин сая дөрвөн зуун таван мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг арван найман мөнгө)	32,988,784.64 (гучин хоёр сая есөн зуун наян найман мянга долоон зуун наян дөрвөн төгрөг жаран дөрвөн мөнгө)	7,416,669.54 (долоон сая дөрвөн зуун арван зургаан мянга зургаан зуун жаран есөн төгрөг тавин дөрвөн мөнгө)